

ЗАМ, ТЭЭВИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН
ТУШААЛ

Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Автотээврийн тухай хуулийн 17¹ дүгээр зүйлийн 17^{1.2}, Захиргааны ерөнхий хуулийн 63 дугаар зүйлийн 63.1, 70 дугаар зүйлийн 70.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хүний амь нас эрүүл мэндийг хамгаалах осол зөрчил гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А\222 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын 3 дугаар зүйлд дараах хэсгийг нэмсүгэй.

1/ Гуравдугаар зүйл:

“...3.3.4...” дэх заалтыг “импортоор оруулж ирсэн шинэ болон ашиглагдаж байсан автотээврийн хэрэгслийн үйлдвэрлэгчийн, эсхүл экспортын дагалдах баримт бичиг, автотээврийн хэрэгсэл экспортлогч улсын экспортлохоос өмнөх үеийн техникийн хяналтын үзлэгийн дүгнэлт” гэж өөрчлөн найруулсугай.

2. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А\222 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын 10 дугаар зүйлд дараах хэсгийг нэмсүгэй.

2/ Аравдугаар зүйл:

“...10.1.8...” дахь заалтын дараа “10.1.9 Жолоочийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 заасны дагуу тээврийн хэрэгслийн өмчлөгч жолоочийн даатгалд даатгуулаагүй” гэж;

3. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А\222 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын автотээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзах хэсгийн “...10.1.9...” дэх гэснийг “...10.1.10...” дахь гэж өөрчилсүгэй.

4. Журамд оруулсан нэмэлт заалтыг иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж ажиллахыг “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ \Б.Гүрсоронзон\-т даалгасугай.

5. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар \Ё.Жаргалсайхан\ -т үүрэг болгосугай.

САЙД

Л.ХАЛТАР